

консулын газрыг. томилсон орон тус бүрийн хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

ГЭРЛЭГСДИЙН ХООРОНДЫН ХУВИЙН
БОЛОН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН
ХАРИЛЦАА

Хорин есдүгээр зүйл

1« Хэрэв гэрлэгсэд Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат бол тэдгээрийн хувийн болон эд хөрөнгийн, эрхийн харилцаа нь тэдний харьяалагдах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулиар тодорхойлогдоно.

2* Хэрэв гэрлэгсдийн нэг нь Хэлэлцэн Тохирогч' нэг Этгээдийн харьяат нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяат бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцаа уг иргэдийн суулийн уед хамт оршин сууж байсан буюу сууж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хууль тогтоомжоор тодорхойлогдош

Гучдугаар- зүйл

1. Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн харилцааны хэргийг тэдний харьяалагдах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн шуух шийдвэрлэх эрхтэй. Хэрэв хэргийг авч хэлэлцэх' уед гэрлэгсэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвгэрт оршин сууж байвал Хэлэлцэн Тохирогч энэхүү Этгээдийн шуух уг хэргийг шийдвэрлэх эрхтэй*

2. Хэрэв гэрлэгсдийн нэг нь Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяат бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааны холбогдолтой хэргийг уг иргэдийн суулийн уед хамт оршин сууж байсан буюу сууж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн шуух шийдвэрлэх эрхтэй.